

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2026 оны 04 сарын 27 өдөр

№ 01

Улаанбаатар хот

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК (цаашид “Сан” гэх)-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дугаар сарын 27-ны өдөр 10:00 цагт цахимаар буюу Сангийн нэгж эрх эзэмшигчдийн албан ёсны фэйсбүүк групп болох **Mandal Ireeduin Osolt ХОС** (линк: <https://www.facebook.com/groups/303072678240799>) группт хуралдаж, хурлын ирц, санал хураалтыг www.investmentexpo.mn сайтаар хураав.

Хурлын дарга: Ганболд БАТЗОРИГ

Тооллогын комисс: Б.Алтанбаяр /Комиссын дарга/

Гишүүд: Г.Төгсбилэг /Ахлах дата аналитист/

Б.Түвшинбаяр /Борлуулалтын ахлах менежер/

Г.Мөнхбаатар /Ахлах хөгжүүлэгч/

О.Галданцэрэн /Сан дэмжих албаны мэргэжилтэн/

Хуралд оролцсон нэгж эрх эзэмшигч нарын тоо: 205

Хуралд оролцсон нэгж эрхийн тоо: 25,437,164 ширхэг

Хурлын ирц: 50.87%

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Хурлын нарийн бичгийн дарга Э.Мишээл хурлыг нээж, Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулав.

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 18-ны өдрийн ээлжит хурлын 26/002 тоот тогтоолоор 2025 оны Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 27-ны өдөр хуралдуулах болсон тухай, сангийн нэгж эрх эзэмшигчдийн албан ёсны **Mandal Ireeduin Osolt ХОС** Мандал Ирээдүйн Өсөлт ХОС (линк: <https://www.facebook.com/groups/303072678240799>) группт хуралдаж дээр хийж, хурлын ирц, санал хураалт, асуултыг хурлын ирц, санал хураалтыг www.investmentexpo.mn сайтаар цахим хэлбэрээр авч буй тухай танилцуулав. Мөн уг шийдвэрийн дагуу бүртгэлийн өдрийг 2026 оны 04

сарын 09-ны өдөр, хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хороонд 2026 оны 03 сарын 19-ны өдрийн дотор хүргүүлсэн, хурлын зарыг өдөр тутмын сониноор 2026 оны 03 сарын 23 болон 2026 оны 04 сарын 07-ны өдрүүдэд тус тус мэдээлсэн болохыг мэдэгдэв.

Хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Алтанбаяр хурлын ирцийг танилцуулав.

- Нэгж эрх эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн нэгж эрх эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.
- Нэгж эрх эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 25,437,164 ширхэг нэгж эрх эзэмшдэг 205 нэгж эрх эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 50,000,000 ширхэг нэгж эрхийн 50.87% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
- Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй нэгж эрхийн 50.87% хуралд оролцож байгаа тул компанийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Тооллогын комиссын дарга хурлын ирцийг танилцуулж, хурал хүчин төгөлдөр болсныг мэдэгдэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1 дүгээр асуудал: Сангийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;

2 дугаар асуудал: Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний 2025 оны жилийн тайланг танилцуулах;

3 дугаар асуудал: Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний 2025 оны жилийн тайланг батлах;

4 дүгээр асуудал: Сангийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

5 дугаар асуудал: Сангийн 2025 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

6 дугаар асуудал: Сангийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

7 дугаар асуудал: ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай;

8 дугаар асуудал: ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай;

1, 2 ДУГААР АСУУДАЛ:

Сангийн 2025 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах

2025 оны Менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланг танилцуулах

Сангийн нийт хөрөнгө 10 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 78.7 тэрбумд хүрч, 14%-ийн өгөөжтэй ажиллав. Сангийн хөрөнгө оруулалтын багцын 25% нь хувьцаа, 18% нь мөнгөний захын хэрэгсэл 53% нь компанийн бонд, 4% хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд тус тус байршуулсан. Мандал Ирээдүйн Өсөлт сан нь 2025 онд 14 хувийн өгөөжтэй ажилласан байна. Мандал Ирээдүйн Өсөлт сангийн хөрөнгө оруулагчдийн тоо анх сан нээгдснээс хойш 1,000 орчмоор нэмэгдсэн буюу 7,884-т хүрсэн байна. Сангийн зах зээлийн ханш 980.87 төгрөг, цэвэр хөрөнгийн үнэ цэн 1574.35 төгрөгт хүрсэн. 2025 онд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан зах зээлд 21.6 тэрбум төгрөгийн дүнтэйгээр 22,970,409 ширхэг нэгж эрх арилжаалагдсан байна.

Монголын хөрөнгийн бирж болон Мандал ирээдүйн өсөлт сангийн шүүхийн маргааны талаар танилцуулж, Иргэний хэргийн дээд шүүхээс “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-аас 187,500,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч “Монголын хөрөнгийн бирж” ХК-д олгож, үлдэх 487,500,000 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн тухай танилцуулав.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 02 сарын 25-ны өдрийн 64-р тогтоолоор “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан. Энэ журмаар хөрөнгө оруулалтын боломж тэлсэн буюу хаалттай хүрээнд гаргасан өрийн хэрэгсэл, сангийн нэгж эрх, Гадаад ЗГ үнэт цаас, ОУ санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл, гадаад улсын зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах боломж нэмэгдсэн тухай танилцуулав.

Сангийн санхүүгийн тайланд хараат бус аудит хийлгэхээр “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК-г сонгосон бөгөөд дүгнэлтээр санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан гэж дүгнэсэн танилцуулав. Мөн үйл ажиллагааны тайланд аудитын дүгнэлтийг дэлгэрэнгүй байдлаар оруулсан тул хөрөнгө оруулагчид танилцах боломжтойг сануулав.

Онцлох үйл явдлуудаас дурдвал харилцагчийн хөрөнгө оруулалт болон бизнесийн шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор эдийн засгийн судалгааг хураангуйлсан “Мөнгө” цахим сэтгүүлийг гаргасан.

Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандартыг амжилттай хэрэгжүүлсэн.

Мөн 2 жил тутам зохион байгуулагдаж, хөрөнгийн зах зээлийн шилдгүүдийг тодруулдаг Гранд Булл авардс 2025 ёслолоос “Шилдэг хөрөнгө оруулалтын менежментийн компани” хэмээх шагналыг хүртсэн тухай тус тус танилцуулав.

3 ДУГААР АСУУДАЛ:

Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний 2025 оны тайланг танилцуулах

Кастодиан банкны хөрөнгө хадгалах үйлчилгээний тайланг Голомт банкны Кастодиан банкны хэлтсийн бизнес хөгжлийн менежер Т.Очир танилцуулав.

2025 онд 34 сая ширхэг 6.5 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий хувьцаа худалдан авах, худалдан борлуулах арилжааг зохион байгуулсан. Мөнгөн хөрөнгийн 2,113 удаагийн гүйлгээг зохион байгуулсан. “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” нь 2021 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс

хойш удирдаж буй хөрөнгийн хэмжээ 57.4 хувиар өссөн, нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэлгээ 57.4 хувиар өссөн байна.

4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Nexia аудитын компани "Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд хараат бус аудитын дүгнэлт гаргасан. Тайлан нь СТОУС-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулагдсан гэж дүгнэсэн талаар танилцуулав.

5 ДУГААР АСУУДАЛ:

Сангийн 2025 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах

2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн цахим санал хураалтаар **2025 оны цэвэр ашгаас** Нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Энэ нь нэгж эрх эзэмшигчдийн өгөөжийг өндөр байлгах зорилготой хэмээн танилцуулав.

6 ДУГААР АСУУДАЛ:

Сангийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах

Танилцуулгын гол агуулга: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг уншиж танилцуулав.

1. ХОС-ийн жилийн үйл ажиллагааны болон аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн асуудлаар:

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС ХХК-ийн ТУЗ нь 2025 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны журам, Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам, ХОС-ын дүрмийн хүрээнд доорх дүгнэлтийг гаргасан. Үүнд:

ХОС нь хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн дагуу амжилттай хийж 2025 оны 12 сарын 31-ний байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ 1574.35 төгрөгт хүрсэн байна.

ХОС нь 2025 онд 10.80 тэрбум төгрөгийн нийт орлогыг тайланд бүртгэж тайлант жилийн цэвэр ашиг 9.12 тэрбум төгрөгт хүрчээ.

2025 онд сангийн хөндлөнгийн аудитаар олон улсын “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК ажилласан бөгөөд 2026 оны 2 дугаар сарын 11-ний өдөр гаргасан дүгнэлтээр “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК-ны 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна гэсэн дүгнэлт гаргасан байна.

2. ХОМК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан

Гүйцэтгэх удирдлага нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримт болон бусад дотоод хууль журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ажилласан байна. Үүнд:

- Сангийн хөрөнгө оруулалтын мэдээллийг тухай бүр хүргэх
- Сангийн үнэ ханшийн мэдээллийг тухай бүр хүргэх.
- ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банканд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх

Иймд 2025 онд “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК-ийн хөрөнгө оруулалтын менежментийн баг төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байна.

7 ДУГААР АСУУДАЛ:

Сангийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах

Танилцуулгын гол агуулга:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэй байхаар шийдвэрлэв.

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	Бичиг хэргийн зардал	2,000,000
2	ТУЗ-ийн хурлын зардал	3,000,000
3	Нэгж эрх эзэмшигчдийн хурал	10,000,000
4	ТУЗ-ийн гишүүдийн цалин /жилээр/	26,000,000
	Нийт дүн	41,000,000

8 ДУГААР АСУУДАЛ:

ТУЗ-н гишүүдийг улируулан сонгох тухай

Танилцуулгын гол агуулга: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн Нэгж эрх эзэмшигчдийн 2023 оны 04 сарын 22-ний өдрийн 07 тогтоолоор томилогдсон Сангийн Төлөөлөн

Удирдах Зөвлөлийн гишүүн болох Г.Халиунааг 5 жилийн хугацаатай улируулан сонгох тухай асуудлыг хэлэлцэв.

9 ДҮГЭЭР АСУУДАЛ:

ТУЗ-н гишүүнийг чөлөөлж, нөхөн томилох тухай

Танилцуулгын гол агуулга: “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн үүсгэн байгуулах 2021 оны 06 сарын 03-ны 21/009 тогтоол, Нэгж эрх эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 21-ний 25/06 тогтоолоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр улиран томилогдсон Н.Монсорын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө буюу 2026 оны 04 сарын 27-ны өдрөөр дуусгавар болгож, сангийн нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлсэн Б.Мөнх-Ирээдүйг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 5 жилийн хугацаагаар томилох тухай хэлэлцэв.

Асуулт хариултын хэсэг:

Асуулт 1:

Сангийн хугацаа дуусахад өсгөсөн мөнгөө хувааж авах уу?

Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа 10 жилийн хугацаатай буюу 2031 онд хаагдана. Одоо бидэнд 5 жилийн хугацаа үлдсэн байна. Хөрөнгө оруулагч та сангийн хугацаа дуусах үед нэгж эрхээ цэвэр хөрөнгийн үнэ цэнээр нь зарах боломжтой. Зах зээлийн ханш одоо 1000 төгрөг орчим байгаа, дараагийн 5 жилд энэ зах зээлийн ханш нь цэвэр хөрөнгийн үнэ цэнрүүгээ дөхнө. Зах зээлийн ханш нь цэвэр хөрөнгийн үнэ цэнээсээ бага байгаа энэ үед сангийн нэгж эрхийг нэмж авах нь ашигтай юм.

Асуулт 2:

2031 онд сан хаах үед ханш ямар байх вэ?

Сангийн зах зээлийн ханш нь цэвэр хөрөнгийн үнэ цэнээсээ хямд байгаа, сангийн хаагдах хугацаа дөхөж байгааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид ажиглаж байгаа байх. Сангийн хугацаа дуусах үед бид цэвэр хөрөнгийн үнэ цэнээрээ хөрөнгө оруулагчиддаа тараана. Ийм учраас зах зээлийн ханш унаж байгаад хөрөнгө оруулагчид санаа зовох зүйлгүй.

Асуулт 3:

Энэ жилийн хүлээгдэж буй өгөөж хэд байх вэ? Банкны эзэн болох ажил юу болов?

Энэ жилийн өгөөж 16%-16.5% орчимд байх төлөвтэй байгаа. Учир нь сан өндөр өгөөжтэй, урт хугацаатай бонд, тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтууд хийж байгаа. Мөн сангийн хувьцааны хөрөнгө оруулалтууд ногдол ашиг тарааж эхэлсэн. Банкны тухай хуулиар нэг хувьцаа эзэмшигч 20%-иас дээш хувьцааг эзэмшихгүй гэж заасан. 2026 ондоо багтааж банкууд хувьцааны төвлөрөлөө бууруулахаар ажиллаж байгаагаа хувьцаа эзэмшигчдийн хурлууд дээрээ ярьж байгаа. Хэрэв банкууд үүнийг хэрэгжүүлбэл бид хувьцааны хөрөнгө оруулалтыг нэмж хийх боломжтой байгаа хэмээн тус тус Хурлын дарга Г.Батзориг нэгж эрх эзэмшигчдээс асуусан асуултад хариулав.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮН

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга Б.Алтанбаяр

Тооллогын комиссын дарга Б.Алтанбаяр: Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. Үүнд:

1. “ХОС-ын 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 14,282,727 ширхэг нэгж эрх буюу 99.96%, татгалзсан 0 ширхэг нэгж эрх буюу 0.00%, түдгэлзсэн 5,170 ширхэг нэгж эрх буюу 0.04% байна.
2. ХОМК болох “Мандал Ассет Менежмент” ХХК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайланг батлах” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 14,237,727 ширхэг нэгж эрх буюу 99.65%, татгалзсан 170 ширхэг нэгж эрх буюу 0.00%, түдгэлзсэн 50,000 ширхэг нэгж эрх буюу 0.35% байна.
3. “Кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайланг батлах” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 14,285,727 ширхэг нэгж эрх буюу 99.98%, татгалзсан 0 ширхэг нэгж эрх буюу 0.00%, түдгэлзсэн 2,170 ширхэг нэгж эрх буюу 0.02% байна.
4. “ТУЗ-ийн 2026 үйл ажиллагааны зардлын төсөв батлах” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 14,179,853 ширхэг нэгж эрх буюу 99.24%, татгалзсан 106,044 ширхэг нэгж эрх буюу 0.74%, түдгэлзсэн 2,000 ширхэг нэгж эрх буюу 0.01% байна.
5. “ТУЗ-ийн гишүүн Н.Монсорыг чөлөөлж, Б.Мөнх-Ирээдүйг нөхөн томилох тухай” асуудлыг хэлэлцэж, батлахыг зөвшөөрсөн 14,235,727 ширхэг нэгж эрх буюу 99.63%, татгалзсан 170 ширхэг нэгж эрх буюу 0.00%, түдгэлзсэн 52,000 ширхэг нэгж эрх буюу 0.36% байна.

Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал 11 цаг 30 минутад өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Э.Миншээл

Хурлын нарийн бичгийн дарга

ТАНИЛЦСАН:



Г.Батзориг

Хурлын дарга